



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 299

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багц/ санхүүжүүлж бий болсон 3 нэрийн, нийт 7,883,300,000.00 (долоон тэрбум найман зуун наян гурван сая гурван зуун мянга) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг Чингис хаан үндэсний музейд эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Чингис хаан үндэсний музейн захирал, академич С.Чулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших эрхийг Чингис хаан музейн нэр дээр баталгаажуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ
132001671
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ...06... дугаар сарын ...13... ны өдрийн
...299... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ЧИНГИС ХААН
ҮНДЭСНИЙ МУЗЕЙД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ангилал	Хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт	
				Огноо	Дугаар
1	"Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн" цогцолбор	"Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн" цогцолборын барилга	1,995,300,000.00	2019.12.12	69/2019
2		"Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн" цогцолборын барилгын интерьер, дотоод уран сийлбэр шинэчлэл, гадна цахилгаан	3,025,300,000.00	2021.12.10	79/2021
3		"Их хуралдай" цогцолборын барилгын коорийн ажил, гадна тохижилт, шугам сүлжээ	2,862,700,000.00	2023.09.28	55/2023
Нийт дүн			7,883,300,000.00		
			(долоон тэрбум найман зуун наян гурван сая гурван зуун мянга)		